



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

Үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн
үнэлгээний үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг шинэчлэн бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.15, Хорооны 2013 оны 453 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам”-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх аудит, үнэлгээний байгууллага, хуулийн компанийг бүртгэх тухай журам”-ын дагуу үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх үнэлгээний компаниар бүртгэгдсэн дараах компаниудыг үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр шинэчлэн бүртгэсүгэй.

1. “Далайван-Аудит” ХХК;
2. “Эвиденсе-Аудит” ХХК;
3. “БДО аудит” ХХК;
4. “Гэрэгэ эстимэйт” ХХК;
5. “Бэсгэ” ХХК;
6. “Үндэсний реалти” ХХК;
7. “Мон үнэлгээ” ХХК;
8. “Лэндс” ХХК;
9. “Кэй Пи Эм Жи аудит” ХХК;
10. “Оюу-Эрдэм Аудит” ХХК;
11. “Хөрөнгийн үнэлгээний төв” ХХК;
12. “Арвижих- Эстимэйт” ХХК;
13. “Мөнх оргил трейд” ХХК;
14. “Хүлэгтхүннү аудит” ХХК;

2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг дээрх нэр бүхий компаниудын захирлуудад үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

030038